



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/79

Шивээговь сум

**Газар эзэмшүүлэх төсөл сонгон  
шалгаруулалт зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухайн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 04 дүгээр “Сумын газар зохион байгуулалтын 2024 оны тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлтээр газар тусгах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 4 (дөрөв)-н нэгж талбарыг малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацааг хавсралтаар баталсугай.

2.Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдөр зарлаж, төслийг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 12:00 цаг хүртэл хүлээн авах ажлыг газрын биржийн цахим системээр зохион байгуулахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2024 оны 06  
дугаар сарын 20-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт



ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ШИЙДВЭРЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ,  
ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ЭЗЭМШҮҮЛЭХ ХУГАЦАА

№	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Эзэмшүүлэх газрын байршил	Талбайн хэмжээ (га)	Зориулалт	Эзэмшүүлэх хугацаа
1	4095419	Хөтлийн ухаан хойд талд	5	Эрчимжсэн мал аж ахуйн ферм	15 жил
2	4095420	Хөтлийн ухаан хойд талд	5	Эрчимжсэн мал аж ахуйн ферм	15 жил
3	4096866	Хогын цэгийн урд талд	5	Мал аж ахуйн үйлдвэрлэл	15 жил
4	4096867	Хогын цэгийн урд талд	5	Мал эмнэлэгийн үйлчилгээний цэг	15 жил